

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны
Төрийн нарийн бичгийн даргын
2013 оны 01 дүгээр сарын 16-ны
өдрийнА/07 дугаар тушаалын
9 дүгээр хавсралт

ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ ЗААВАР

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин (Үр дүнгийн гэрээний биелэлт)-г үнэлж дүгнэхэд энэхүү зааврыг мөрдөнө.

1. Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн жинхэнэ албан хаагчид (Төсвийн шууд захирагч, Менежер, Төрийн жинхэнэ албан хаагч, Харьяа байгууллагын төсвийн шууд захирагч) Үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтээ Хүснэгт 1-ийн дагуу тайлагнана.

Хүснэгт 1

| № | Үр дүнгийн гэрээнд тусгагдсан ажил, үйлчилгээ | Гэрээгээр хүлээсэн хүрэх үр дүн | Гүйцэтгэл, хүрсэн үр дүн | Үнэлгээ | |
|---|---|---------------------------------|--------------------------|---------|---------------------------|
| | | | | Өөрийн | Холбогдох албан тушаалтны |
| | | | | | |
| | | | | | |

2. Үр дүнгийн гэрээнд тусгагдсан ажил үйлчилгээ, арга хэмжээний биелэлтийг үнэлж дүгнэхдээ Хүснэгт 2-д заасан үнэлгээний зарчим, аргачлалыг баримталж үнэлнэ.

Хүснэгт 2

| № | Үнэлэх зарчим | Үнэлгээ | Нийт болон дотоод бүтээгдэхүүн | Тусгай захиалгат бүтээгдэхүүн | Мэдлэг чадвар |
|---|---|---------|--------------------------------|-------------------------------|---------------|
| 1 | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан тавьсан зорилтод бүрэн хүрсэн, энэ талаар холбогдох шийдвэр, үр дүн гарсан | 100% | 30.0 | 40.0 | 30.0 |
| 2 | Тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн хийгдсэн, аливаа шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлсэн | 80-99% | 24.0-29.7 | 32.0-39.6 | 24.0-29.7 |
| 3 | Тавьсан зорилтод хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах асуудлыг шийдвэрлэсэн, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлсэн | 60-79% | 18.0-23.7 | 24.0-31.6 | 18.0-23.7 |
| 4 | Тавьсан зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн | 40-59% | 12.0-17.7 | 16.0-23.6 | 12.0-17.7 |
| 5 | Тавьсан зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дууссан болон боловсруулалтын шатанд шилжсэн | 20-39% | 6.0-11.7 | 8.0-15.6 | 6.0-11.7 |
| 6 | Тавьсан зорилтыг хэрэгжүүлэх тооцоо судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон арга хэмжээг авч эхэлсэн | 10-19% | 3.0-5.7 | 4.0-7.6 | 3.0-5.7 |
| 7 | Тавьсан зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй | 0 | 0 | 0 | 0 |